



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2026 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

**Нэр дэвшигчийн томилгооны сонсголын тов тогтоох,
сонсгол даргалагчийг сонгох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалт, 30.3, 30.4 дэх хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5.2 дахь заалтыг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос **ТОГТООХ** нь:

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчидтэй хийх томилгооны сонсголыг 2026 оны 10 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2.Нэр дэвшигчийн томилгооны сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийг томилсугай.

3.Нэр дэвшигчийн томилгооны сонсголын талаар нийтэд мэдээлэх, сонсголын бэлтгэл хангах ажлыг холбогдох хууль, журамд заасны дагуу зохион байгуулахыг Хууль зүйн байнгын хороо (Л.Мөнхбаатар)-нд даалгасугай.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Л.МӨНХБААТАР